



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 дугаар сарын 22

№ 01/48 ДУА-2018/82/СТА-ТШЗ

Мандалговь хот

Г

Төлбөр барагдуулах тухай

Т

Аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Өндөршил сумын Цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын шилдэг ажилтан болсон 2 албан хаагчид үндсэн цалингийн зардлааас 307,351/ Гурван зуун долоон мянга гурван зуун тавин нэгэн / төгрөгийн шагнал олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхад толовлож зарцуулах/, 7.3-д /Төсвийг нэгжилээр баталж, тайллагнах болгөөд батлагдсан төсвийг сар, улирагаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна/, 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих/, 16.5.5-д /батлагдсан төсвийг зориуулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ын /Үндсэн цалин-Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана/ гэж заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.7-д /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал/ гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Шагналд олгосон 307,351.00 /гурван зуун долоон мянга гурван зуун тавин нэгэн/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж аймгийн төрийн сангийн 100080000955 дугаар дансанд 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор тус тус төвлөрүүлэх.


2. Актын биелэлтийг 2018 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Өндөршил сумын Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн шууд захирагч Д.Номин-Эрдэнэ, нягтлан бодогч Х.Үнэнтунгалаг нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН¹:
АУДИТОР Г.ДОЮУН-ЭРДЭНЭ



ЗӨВШӨӨРСӨН:
ЭРХЛЭГЧ: Д.Н.Э/ д.НОМИН-ЭРДЭНЭ
НЯГТЛАН БОДОГЧ: Н.Ф.Х.ҮНЭНТУНГАЛАГ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.